

НИГҮҮЛСЛИЙН АЯЛАЛ

АРИУСГАХ

НИГҮҮЛСЭЛ

4 долоо хоногийн хичээл

ДЭН БҮҮН

АРИУСГАХ

НИГҮҮЛСЭЛ

4 долоо хоногийн хичээл

ДЭН БҮҮН

2024 он

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан © 2023 Фаундри хэвлэлийн газар®

Анхны хувилбар

Ариусгах Нигүүлсэл

Дэн Бүүн

Энэхүү хэвлэлийг Фаундри хэвлэлийн газар болон Олон Улсын Назарын хэвлэлийн газар хамтын харилцаагаар зохицуулагдсаны дагуу хэвлэв.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү номын аль ч хэсгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, ямар ч хэлбэрт шилжүүлэн ашиглах- электрон хэлбэрт хөрвүүлэх, олшруулах, дүрс дуу бичлэгээр хадгалахыг хориглоно. Харин хэвлэмэл бичвэрт эш татан ашиглаж болно.

Хавтасны загварыг Роб Моначелли

Доторх загварыг Шэрон Пэйж

Орчуулсан О.Дөлгөөн

Хянасан С.Бямбасүрэн

Библийн эшлэлүүдийг Ариун Библи Нийгэмлэгийн Ариун Библийн 2013 оны орчуулгаас ашигласан болно.

Энэхүү номд тусгагдсан интернэт хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар нь хэвлэлтэд орох үедээ хэвийн ажиллаж байсан бөгөөд эх сурвалж болно. Фаундри хэвлэлийн газар нь ямар нэг байдлаар тэдгээрийг батлах, агуулга болон тогтвортой байдалд хариуцлага хүлээхгүй.

АГУУЛГА

1-р долоо хоног
Ариунаар дуурсагдах Нэр

4

2-р долоо хоног
Ирэх Хаанчлал

20

3-р долоо хоног
Бүлгийн Ариусгал

37

4-р долоо хоног
Ариусгагч Сүнс

51

1-Р ДОЛОО ХОНОГ

АРИУНААР
ДУУРСАГДАХ НЭР

Брэнд хөгжүүлэх, хамгаалах нь өнөөгийн нийгэмд томоохон бизнес болоод байна. Байгууллагууд өөрийн нэрийг хамгаалахын тулд хуулийн фирмүүдтэй хамтран ажилладаг. Тэд брэндийн нүүр царай болох олны танил алдартнуудыг сонгохдоо ч няхуур судалдаг бөгөөд тухайн хүн брэндийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл гаргавал тэр даруй хамтын ажиллагаагаа цуцалдаг. Брэнд хэрэглээ гэдэг нь хуулийн хүрээнд маш чухалд тооцогддог зүйл юм. Иймээс нэрийг нь буруугаар ашиглах, буруу илэрхийлэх, сэв суулгах нь ноцтой асуудалд тооцогддог.

Их Эзэний заасан залбирал “Тэнгэрт байгаа бидний Эцэг минь, Таны нэр ариунаар дуурсагдаг.” (Матай 6:9) гэж эхэлдэг. Энэ нь тийм ч гайхаад байхаар зүйл бишээ. Эцсийн эцэст, бид Арван Хуулийн хүмүүс. Хүүхдүүдэд ч хүртэл “Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд. Учир нь ЭЗЭН Өөрийнх нь нэрийг дэмий дурдагчийг шийтгэлгүй орхихгүй.” (Египетээс гарсан нь 20:7) гэж заасан. Бичээс бидэнд Бурханы нэрийг гутаахгүй байхыг дахин дахин анхааруулдаг. Энэ нь маш чухал. Бурханы нэр Бурханы хүмүүсээр ариунаар дуудагдах ёстой.

Мосе Бурханы нэрээр ярих үед ус цус болж, мэлхий, шумуул, ялаа шавж, тахал гарч, аянга цахиж, мөндөр бууж, царцаан сүрэг дайрч, харанхуй нөмрөн, үхэл залгиж, далай ярагдаж, хаднаас ус гарч, тэнгэрээс талх унаж байсан. Хүмүүс Ариун Бурханыхаа нэрээр чөлөөлөгддөг байсан. Мосе Нэрийг нь дуудахад л, Бурхан хийдэг байсан. Бурханы нэрэнд хэмжээлшгүй хүч бий. Сул дорой хүмүүс бид хүч чадлыг өөрсдийнхөө гарт оруулж, хувийн ашиг сонирхлынхоо төлөө ашиглахыг шунан хүсдэг учраас Түүний нэрийг дэмий бүү дурд гэсэн гурав дахь хууль бидэнд өгөгдсөн байх. Бурханы хийхгүй зүйл дээр Бурханы нэрийг бүү ашигла.

=====

**Бурханы хийхгүй зүйл дээр
Бурханы нэрийг бүү ашигла.**

=====

Би амьдралынхаа ихэнх үед Эзэний нэрийг дэмий дурдахгүй гэдгийг хараал хэлэхгүй байх тухай хэлсэн гэж ойлгодог байлаа. Ямар нэг хараал хэлэхдээ Бурханы нэрийг мөн Гурвалын хэнийх нь ч нэрийг бүү дууд. Иймэрхүү байдлаар хүндэтгэлгүй хандах нь Бурханы нэрийг буруугаар хэрэглэж буйн нэг хэлбэр мөн боловч Бурхан зөвхөн үүнээс болж хууль өгсөн гэж бодохгүй байна. Бурханы нэрийг тээгч бидний үйлдэл Бурханы жинхэнэ зан чанарыг илэрхийлж чадахгүй бол бид Түүний нэрийг дэмий дуудсанаар Түүнийг гутааж буй хэрэг юм. Бурхан бидний бодол, хэрэгцээг маань баталж байгаа мэтээр Түүний гарын үсгийг хуурамчаар дуурайж байгаагаараа бид Түүний нэрийг гутааж байгаа гэсэн үг. Чуулганы нэг гишүүн надад “Бурхан таныг надад 100 доллар өг гэж хэлсэн” гэж билээ. Бурхан уг нь надад өөрт маань хэлэхээс хэзээ ч цааргалж байгаагүй юмсан. Бас нэг ажилтан надад “Бурхан таныг надаар онцгой ажлыг онцгой хийлгэхийн тулд ажилд авах хэрэгтэй гэж илчилсэн” гэж хэлж байсан. Христэч их сургуулийн дор хаяж нэг оюутан өөрийнхөө болзож буй бүсгүйдээ Бурхан чамайг миний эхнэр болно гэсэн гэж хэлдгийг бүгд мэдэх байх.

9-р сарын 11-ний үйл явдал бол Америкчуудад үзүүлж буй Бурханы шүүлт, эсвэл Бангладешт болсон цунами нь Бурхан муслимчуудыг шүүж байгаа хэрэг, эсвэл Гайтид болсон газар хөдлөлт нь чөтгөрийн эмч нарт үзүүлж буй Бурханы шүүлт гэж хэлэх нь өөрөө Бурханы нэрийг буруугаар ашиглаж байгаа хэрэг болно. Хүмүүс маш олон “үзэл бодлын чек” үүсгэж түүн дээрээ Бурханы нэрийг ашиглан хуурамчаар гарын үсэг зурдаг. Энэ үйлдэл нь Бурханы нэрийг гутааж буй явдал. Бурханы нэрийг шошго болгон бусдад шахаж буй бүтээгдэхүүнүүдийг юу гэх вэ? Бидний үзүүлж буй

үйл ажиллагаа болгонд Бурхан үнэхээр байна уу?

Зарим эрчүүд өөрсдийнхөө үйлдлийг Христтэй адил бурханлаг гэж тодорхойлчихоод эхнэрүүдээ номхон, хүлцэнгүй байлгахын тулд Бичээсийг буруугаар ашигладаг. Бурханы нэрийн өмнөөс гэж тулалдсан маш олон, бүр маш олон дайн тулаанд Бурхан ямар ч хамаагүй байсан. Хүмүүсийн бий болгосон бөгөөд “Бурханы хүслийн дагуу” гэж тайлбарлагдсаар ирсэн сөрөг нөлөө бүхий нийгмийн бодол, хандлага хэдэн зууны турш байсаар л байна. Бэлгийн хүчирхийлэл Бурханы нэрийг барьж гарч ирсэн. Бурханы ажлыг хийж байна гэж тунхагладаг үйлчлэлүүдэд хов жив гарсан. Би бүр зарим номлогч нар хэн нэгнийг эдгээснийхээ төлөө эсвэл гайхамшгийг (ирээдүйд болох болон болохгүй) мэдүүлснийхээ төлөө тэтгэврийн хүмүүсийг амин зуулгын орлогоос нь салгачхаад үүнийгээ бурханлаг зүйл гэж ярьж байхыг ч харж байлаа. Хүмүүс Бурханы нэрийг барин хуурч мэхэлдэг. Бид энэхүү хүчирхэг нэрээс зуурахдаа Бурханы үнэн мөн чанар ба үйлчлэлийн талаар нухацтай бодолгүйгээр зүгээр л хувийн зорилгоор ашигладаг. Хэрэв бид нэлээд алдартай брэндийн нэр хүндэд тэгж хандвал учруулсан хохирлынхоо төлөө шүүхэд дуудагдах болно.

Бурханы нэрийг буруугаар ашиглахыг Есүс маш ноцтойгоор чухалчилж анхаардаг байсан. Уулан дээрх сургаалын төгсгөлд “Намайг ‘Эзэн минь, Эзэн минь’ гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. Тэр өдөр Надад олон хүн ‘Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?’ гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд ‘Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл гэж хэлнэ” (Матай 7:21–23) гэж хэлснийг

бид мэднэ. Бурханы нэр бол буруугаар эсвэл хөнгөн хуумгай ашиглаж болох зүйл огт биш юм аа. Бид энэ нэрийг өөрийнхөө санаа бодол, бараа бүтээгдэхүүн, эсвэл хэлэх үгэндээ зүгээр л хавчуулчихдаг байж болохгүй. Бид үнэхээр л Бурханы ариун ажлыг хийгээгүй л бол өөрсдийн төлөвлөгөөндөө Бурханы нэрийг хавсаргаж дурдахгүй байцгаая.

=====

**Бид үнэхээр л
Бурханы ариун ажлыг хийгээгүй л
бол өөрсдийн төлөвлөгөөндөө
Бурханы нэрийг хавсаргаж
дурдахгүй байцгаая**

=====

Би ч гэсэн Бурханы нэрийг гутааж явсан гэдгээ улайх хэрэгтэй. Би бусдад эелдэг бусаар хариулж, хамгийн чухал зүйлээсээ гажиж, өгөөмөр сэтгэлээр бусдад өгөхөөс илүүгээр материаллаг зүйлд мөнгөө зарж, хэл үгэндээ ч төөрөлдөн, Бурхантай огт адил биш мөртлөө Бурханы нэрийг дуудаж явсан үе бий. Бидний үйлдэл, үг, аливаа үйлс нь дагана гэж тунхагласан Бурханыгаа гутааж байгаа л бол Түүний нэр бидний дунд байхгүйн дээр ариунаар дуурсагдана гэж үгүй. Тиймээс бид “Таны нэр ариунаар дуурсагдаг” гэж залбирдаг. Бурханы ариусгагч нигүүлслийг амсахын тулд бид энэ гуйлтыг хийх шаардлагатай. Энэ бол Есүсийн ариун байдлыг бидэнд харуулах гуйлт мөн.

Цорын ганц ариун Нэгэнтэй байх дотно харилцаагаар л хүмүүс бидний ариун байдлын төлөөх өл дарагдаж, цаддаг. Бурханы ариун байдал бол бие даасан, онцгой, өвөрмөц ангилал юм. Бурханы нэртэй эн зэрэгцэх юу ч үгүй. Зөвхөн Бурхан л жинхэнэ ариун. Бурхан бол ариун байдлын эх сурвалж билээ. Бурхантай холбоотой бүх зүйл ариун, харин холбоогүй бүх зүйл ариун бус. Тийм ч учраас Есүс бидэнд хэрхэн залбирахыг Өөрөөрөө үлгэрлэн зааж харуулахдаа Бурханы ариун нэрээр залбирлаа эхлүүлсэн нь Ариун Бурханы оршихуй руу биднийг хөтлөн, Бурханыг амьдралдаа дуудан ирүүлж, өөрсдийг маань болон хийх бүх зүйлсийг маань Бурханд өргөн даатгахын тулд байсан. Бидний амьдрал Бурханы нэрийг нэг бол ариунаар дуурсгана эсвэл гутаана.

Нэг оюутан бүтэхгүй буруу зүйлтэй хутгалдсан хэдэн найзуудтайгаа хамтдаа цаг өнгөрөөж байжээ. Тэдний үйлсийнх нь ёс суртахуунгүй байдлыг ярих ч юм биш. Зүгээр л тэр чигээрээ буруу байлаа. Тэдэнтэй нийлж буруу зүйл хийхийн оронд тэр хүүхэд зүгээр л орхиод явчихав. Харин зарим нь үлдсэн бөгөөд дараа нь тэнд

хүмүүс бэртэж, нэр хүнд нь сүйрч, ноцтой үр дагавар дагуулсан асуудал үүссэн юм. Тэр оюутан яагаад өөрийгөө тэр хэсэг бүлэг хүмүүсээс тусгаарласан бэ? Тэр яагаад тэндээс явсан юм бол? Найзуудаасаа эсрэг явахад хүүд юу нөлөөлсөн юм бол? Тэрээр “энгийн зүйл л дээ” гэж тайлбарласан байдаг. “Миний өвөө эмээ ариун хүмүүс байсан. Тэд намайг хайрлаж, надаар бахархдаг байсан. Тэд золиос гаргасан учраас би Христэч их сургуульд явах боломжтой болсон юм.” Тэгээд тэр нэг сонирхолтой зүйл хэлсэн юм. “Би өвөө эмээгийнхээ нэрийг гутаамааргүй байна. Би тэдэндээ дэндүү хайртай”. Бид тээж буй нэрээ бусдад харуулах төлөөлөл билээ.

Их сургуулийн ерөнхийлөгчийн хувьд би дуртай ч, дургүй ч сургуулийнхаа биет буюу явдаг нэрийн хуудас нь. Манай сургуулийн олон нийттэй харилцах баг, спортын баг, зуны илгээлтийн баг, профессорууд, мөн оюутнууд ч манай сургуулийн нэрийн хуудас, нүүр царай болдог. Хүмүүс биднээс харсан зүйл дээрээ үндэслэн сургуулийг маань дүгнэнэ шүү дээ. Тийм ч учраас би Кайлд маш их хайртай. Түүний суурь боловсролын дүн нь түүнийг аль ч их сургуульд оруулахуйц байсан. Тэр математик, шинжлэх ухааны хичээлүүддээ онцгой байсан юм.

Харамсалтай нь, Кайл тархины хорт хавдартайгаа тэмцэж байлаа. Тэр өглөө нь химийн эмчилгээндээ орчихоод өдөр нь хичээлдээ явдаг байсан юм. Кайл маш тэвчээртэй, үнэхээр хүчтэй итгэлтэйн дээр хошин шогийн мэдрэмжтэй, сайн найзуудаар хүрээлэгдсэн нэгэн байлаа. Хойд Каролина мужийн Ралейд түүний оршуулах ёслолд оролцох нь миний хувьд нэр төрийн хэрэг байв. Тэрээр хичээлүүдээ дуусгаж, сургуулиа төгсөж хараахан амжаагүй учраас зан чанар ба эр зоригийн өндөр зэрэг хамгаалсан боловсролын

гэрчилгээг эцэг эхэд нь гардуулж өгсөн юм. Кайлыг сургуулийн нүүр царай, төлөөлөл болгоход би бэлэн. Тэр Бурханы нэрийг ариунаар дуурсгаж чадсан. Бурхан түүний амьдралд агуу байр суурь эзэлдэг байлаа.

Бурхан бидний дундаас цөөхөн хэдэн тууштай хүнийг Өөрийнх нь нэрийг тээгчээр сонгож авдаггүй. Бурханы бүх хүүхдүүд түүний нэрийг тээдэг “явдаг брэнд” гэдгээс болж заримдаа би тэнгэр үрүү хараад “Та юу бодож байсан юм бэ?” ч гэж хэлдэг. Бурханы нэрийг бидэн шиг хүмүүст итгэж даатгах нь асар их эрсдэл. Магадгүй Тэнгэрлэг Нэрийн өмнөөс ажилладаг хуульч нар Нэрийг нь буруугаар ашиглаж байгаа хүмүүсийг хайж олоод шүүхийн танхимд дуудаж, шүүх хэрэгтэй байсан байх. Бурхан бидэнд Өөрийн нэрээр баптисм хүртээж, Өөрийнх нь нэрээр юуг ч хамаагүй гуйх боломж олгон, нэрийг нь ашиглан өөрсдийнхөө үйлсийг тамгалан бүтээ гэхдээ юу хийж байгаагаа мэдэж байсан болов уу? Бусад бурхад өөрсдийн дүр төрхийг харуулахуйц баримал, зурагтай байдаг. Тийм ч учраас тэднийг шүтдэг хүмүүс амьгүй бурхдынхаа хэлбэр төрхийг нь дордуулж муутгачихгүй байлгахыг хичээдэг шүү дээ. Харин бидний Бурхан Өөрийнхөө Нэрийг бидэнд өгч Өөрийн дүр төрхийн дагуу биднийг бүтээснээрээ Нэрээ ариунаар дуурсгадаг. Бид бол Есүсийн хүмүүс, Христийн бие, Бурханы дүр төрх билээ. Тиймээс хүмүүс биднийг харахдаа дотор маань амьдардаг, бидэнтэй хамт байдаг Бурханыг хараасай гэж залбирдаг.

Бид бол явдаг брэнд бөгөөд энэ нь Бурханд маш чухал.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

ЗАЛБИРЦГААЯ

Биднийг ажиглаж буй энэ дэлхийд таны амьдрал Есүсийг хэр итгэмжтэйгээр төлөөлдөг вэ? Хэрэв найзууд чинь таны амьдралаас Бурханы тухай дүгнэлт гаргавал ямархуу Бурханыг танаас харах бол? Түүний нэрийг ариунаар дуурсгаж байгаагаа баттай мэдэхийн тулд танд Бурханаас юу хэрэгтэй вэ?

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Эзэний нэрийг дэмий бүү дууд гэдгийг та хэрхэн ойлгосон бэ?

2. Ариусгах нигүүлсэл нь биднийг хэрхэн Христийн итгэмжит төлөөлөгч болгодог вэ?

3. Дэлхий Есүст хайртай ч Христэд итгэгчдийг үзэн яддаг гэж хэлдэг. Христ болон Түүний дагалдагчдын хооронд яагаад ийм зааг үүссэн юм бол? Энэхүү заагийг ариусгах нигүүлсэл хэрхэн арилгах вэ?

4. Бурханы нэрийг ашилахдаа энэ нь Түүний нэр хүндэд сөргөөр нөлөөлж байвал бид юу хийх ёстой юм бол?

5. Бурхан Өөрийнхөө нэрийг бидэнтэй хуваалцсан нь сайнмэдээ мөн үү? Яагаад?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

2-р долоо хоног

ИРЭХ ХААНЧЛАЛ

9-р ангид байхдаа би найз Жимтэйгээ хамт үл мэдэгдэх нисдэг биетийн тухай тайлан бичсэн юм. Бид хоёр зураг цуглуулан, тухайн биетүүдийг харсан хүмүүсийн түүхийг уншаад зогсохгүй бүр тухайн биетээр хулгайлагдсан гэх хүмүүсийн хэргийг хүртэл судалж үзсэн. Нисдэг биетээр хулгайлагдаад харь гаригийн хүмүүсийн байцаалтад орсон гэх нэг залуугийн тухай бид хоёр сонссон. Бид тэр залуутай уулзахаар гэрт нь очоод, даруухан зочны өрөөнд нь суунгаа түүний түүхийг бараг нэг цагийн турш сонслоо. Тэгээд биднийг явах болоход нөгөө залуу дуугаа намсгаад, яг л хэн нэгэн түүнийг сонсчих вий гэсэн шиг “хөвгүүдээ та нар тэднийг харахгүй байгаа байх л даа, гэхдээ тэд нар энд байна” гэж шивнэж билээ.

Интернэтийн сүлжээ яг л энэ зүйлтэй адилхан санагдаж миний анхаарлыг татсан юм. Интернэт сүлжээ тухайн өрөө эсвэл тэр орчинд байдаг ч бид тааз эсвэл сандлын доор шагайж харлаа ч сүлжээ бидний нүдэнд харагдахгүй. Харин бид сүлжээнд нэвтэрч хэрэглэх юм бол л сүлжээ байгааг мэднэ. Тэгэхээр үнэхээр бодитоор байгаа мөртлөө бидэнд огт мэдэгдэхгүй тийм зүйл байж л байдаг.

Би нэг удаа Христмасын баярын үеэр дэлгүүрийн хоолоор үйлчилдэг хэсэгт Халлелүяа дуун дээр хэсэг хүмүүс флашмоб бүжиглэж байгаа бичлэг үзсэн юм. Дараа нь би тэр дэлгүүрээр явж байхдаа өөрийн эрхгүй хоолоор үйлчилдэг хэсэгт нь гэнэт дуу яваад хүмүүс гараад ирэхгүй байгаа гэж бодож билээ. Юмыг яаж мэдэхэв, намайг мэдээгүй байхад чанх урд минь үсрээд гараад ирж магадгүй шүү дээ.

Бид анзаарахгүй байгаа ч бидний байгаа газар бүрт ямар нэг зүйл байгаа юм байна гэдэг энэ ойлголт надад гайхалтай санагдсан юм. Нисдэг биет, интернэт сүлжээ, флашмоб бүжгийн арга хэмжээ гээд. Тэд

мэдэгдээгүй, танигдаагүй боловч одоо ч байсаар байж болох юм. 1972 онд намайг их сургуулийн 2-р курсийн оюутан байхад манай чуулганы номлогч Стэнли Жонс Бурханы хаанчлалын тухай ярихад би яг л ийм бодит байдалтай нүүр тулах шиг болсон. Хэдийгээр 50 гаруй жил өнгөрсөн ч түүний ярьсан зүйл одоо ч миний сэтгэлийг татсаар хэвээр.

Бурханы хаанчлалын тухай та юу мэдэх вэ? Сайнмэдээний номнуудаас уншвал Есүсийн хамгийн эхний сургаал нь Бурханы хаанчлалын тухай байгааг харж болно. Марк номын эхэнд “Иоханыг хоригдсоны дараа Есүс Галилд ирж, Бурханы сайнмэдээг тунхаглан, — Тэр үе биелэлээ оллоо. Бурханы хаанчлал ойрхон байна. Гэмшиж, сайн мэдээнд итгэгтүн гэж байлаа.” (1:14-15) гэсэн байдаг. Есүс Бурханы хаанчлалын тухай бусад сэдвээс илүү их заасан.

Хэрвээ би танаас “ Бурханы хаанчлал гэж юу вэ?” гэж асуувал та юу гэж хариулах вэ? Зарим нь бидний нас барсныхаа дараа очих газар гэж хэлэх байх. Зарим нь бидний хамгаалагдах, хоргодох эцсийн аюулгүй газар гэж хэлэх байх. Бурханд үйлчилдэг чуулган гэж ч хэлж магадгүй. Өөр бас хэрэв бид санал болон мөнгөө хангалттай өгч чадвал дэлхийд ирэх засгийн газар, мөн Есүс эргэж ирэх үед бидэнд өгөгдөх ирээдүй гэж хэлэх байх. Харин та юу гэж хариулах вэ?

Би Хаанчлалыг нисдэг биет, интернэт сүлжээ, болон флашмоб бүжигтэй жоохон төстэй гэж хэлсэн. Бурханы хаанчлал бол Бурханы оршихуйгаар гарцаагүй дүүргэгдсэн бодит улс, бодит ертөнц, бодит орчин юм. Та бүхнийг газар зүйн байрлалын хувьд ч гэсэн нэг зүйлийг мэдэж аваасай гэж хүсч байна. Бурханы хаанчлал тээр дээр бидний харж чадах хамгийн хол одноос цаана, сансрын хөлөг ч хүрч чадахгүй газарт байгаад бид энд доор байдаг юм бишээ. Бид энд байна.

Бид мэддэг ч бай мэддэггүй ч бай Бурханы хаанчлал ч гэсэн энд байдаг. Тэгэхээр үүлний цаана хаа нэгтээ биш харин бидний амьсгалтай яг адилхан тийм ойрхон байдаг гэсэн үг. Бурханы хаанчлал нүдэнд харагддаггүй ч зарим харагдахуйц талбарт нэвтэрч эрс өөрчлөлтийг хийдэг. Есүс Христ хүн болж ирсэн учраас бидний дунд Бурханы хаанчлал ирсэн юм.

=====

**Бурхан хаанчлал гэдэг бол
Бурханы оршихуйгаар гарцаагүй
дүүргэгдсэн бодит улс,
бодит ертөнц, бодит орчин юм.**

=====

Дагалдагч нар нь Есүсээс хэрхэн залбирахыг бидэнд заагаач гэхэд Тэрээр зөв залбирал нь Бурханы нэрийг ариунаар дуурсгахыг, Бурханы хаанчлал ирэхийг, Бурханы хүсэл биелэхийг бусад бүх зүйлээс дээгүүрт тавих ёстойг биечлэн харуулсан. Энэ гурван зүйл нь ижил утгатай. “Бурханы нэр ариунаар дуурсагдах” гэдэг нь “Бурханы хаанчлал ирэх”=“Бурханы хүсэл биелэх”. Эдгээр нь бидний амьдрал дахь ариусгах нигүүлслийн бодит байдлыг тайлбарладаг гурван өөр зүйлс юм.

Есүс Бурханы Хаанчлалын тухай маш олон зүйлийг ярьсан. Товчхон базаад харвал:

Та нарын дунд байгаа.

Бүрэн дүүрэн байдал дотор ирнэ, гэхдээ бас аль хэдийн ирсэн.

Гэмшээд хаанчлал руу ор.

Юун түрүүнд Бурханы хаанчлалыг хай, тэгвэл та нарын бүх хэрэгцээ хангагдах болно.

Бурханы хаанчлал бол даруу, сүнсэн дотроо ядуу, зөвт байдлын төлөө хавчигдагсдынх юм.

Гичийн үр шиг жижиг, өчүүхэн зүйлээс эхэлдэг.

Талбайд нуусан сайн сувдыг хайхтай адил.

Хэзээ ч тийшээ орохгүй дээ гэж бодсон хүмүүсийн нэр урилгын жагсаалтад байгаа.

Зарим тохиолдолд чуулганд сайн явдаг хүмүүсээс гэмтэй мөртөө даруухан хүмүүс хаанчлалтай илүү ойрхон байдаг.

Хуучин туламд хаанчлалыг хадгалах боломжгүй, учир нь шинэ дарс шиг тулмаа зад татна.

Энэ нь яг л өөрийн мөнгөө зарцдаа үлдээгээд, өгсөн мөнгөөр нь сайн зүйл хийнэ гэж итгээд хотоос явж буй баян хүнтэй адилхан.

Хаанчлал бол ирэх зохисгүй хүмүүсийг урьсан найрын арга хэмжээтэй адилхан.

Хэрэв өвчтэй хүн эдгэрч байвал хаанчлал тэнд

байна гэсэн үг.

Сатан ум хумгүй зугтаж байвал хаанчлал тэнд байна.

Хэрэв ядуу, хоригдсон, хэрэгцээ нь хангагдаагүй хүнийг харахдаа Есүсийг харж байвал хаанчлал ирсэн байна гэсэн үг.

Бурханы хаанчлал дэлхийд цөмлөн орж ирснээр ертөнцийг зөв болгоно гэсэн найдвараар бид энэхүү эрсдэлтэй залбирлыг хийдэг. “Таны хаанчлал ирэх болтугай, хүсэл тань тэнгэрт шигээ энэ газарт биелэх болтугай” гэдэг залбирал нь амьдралыг хамгийн ихээр өөрчлөх, бүрэн дүүрэн, аймшигтай, үр дагавар авчрахуйц залбирал мөн. Ингэхдээ бид утга учрыг нь сайн ухаарахгүйгээр залбирдаг байж магадгүй. Тийм ч учраас нэг их зүйл тохиолддоггүй байх. Гэхдээ бид утга учир өгдөггүй зүйлээ залбирсаар байгаад дасал болжээ. Ихэнх цуглааны үеэр Эзэний нэрээр залбирахдаа “Бидэнд зүйлийн төлөө залбирах зоригийг өгөөч” гэж залбирахыг уриалдаг. Биднийг зоригтой болгох оо? Бурханы хаанчлал ирэхийн тулд танд залбирах зориг хэрэгтэй гэж та бодож байсан уу? Үнэн хэрэгтээ, хаанчлалын төлөөх залбирал нь хулчгар хүмүүсийн залбирал биш. Учир нь энэхүү залбирал нь дэлхийг захирч буй хүчнүүдийг үгүйсгэдэг залбирал юм. Энэ бол чөлөөлөлтийн залбирал. Зохион байгуулалтай террорист бүлэглэлийнхээс ч илүү эрс эргэлтийг эрэлхийлдэг залбирал юм. Гэхдээ зүгээр нэг итгэл үнэмшил, улс төрийн нам, эсвэл хөл бөмбөгийн улиралд гаргадаг зориулалтаас илүү зүтгэл шаардана. Дэлхийг Бурханы хүсэл биелдэг газар байлгахын тулд бид энэхүү залбирлаар Бурханыг засаглалаа бүхий л аргаар бүх газар тогтоогооч гэж гуйдаг. Өөрөөр хэлбэл бид барыг торноосоо гараач гэж урьж байгаа хэрэг. Харин тэр бар нь зүгээр нэг номхон бар биш.

=====

**Бид Бурханы хаанчлалыг хүлээн авч,
хаанчлалын дагуу амьдрахын тулд бүх
хүний нүдний өмнө ил оршдог.**

=====

Хэрэв бид “Таны хаанчлал ирэх болтугай” гээд залбиртал Бурхан “За, Би бүх бэрхшээлийг алга болгоод Өөрийн хаанчлалыг бүрэн дүүрнээр буулгая” гэвэл дэлхий ямар болох бол гэж гайхаж байсан удаа танд бий юу? Ямар байх байсан бол? Би дараах байдлаар таамаглаж байна. Эд хөрөнгүүдийг дахин хуваарилаад бидний ихэнх нь одоо байгаагаасаа бага зүйлтэй болох байх. Цэрэг арми хэрэггүй болох байх. Вашингтон ДС хот эрх мэдэл, хүч чадлын гол суудал байхаа болих байх. Дөлгөөн хүмүүс дэлхийг өвлөн авах байх. Дэлхий бидний бий болгосон бохирдлуудаас ангижирч, нөхөн сэргээгдэх байх. Бидний дунд буй сул дорой нь хүчирхэгжих байх. Бардам, дээрэнгүй хүмүүс газартаа буух байх. Хүч чадлаа зөвхөн хөршдөө туслахын тулд л хэрэглэдэг болох байх. Шударга ёс хэрэгжих байх. Эрүүл мэндийн асуудал олон улсын асуудал болж, өлсгөлөн хүмүүс хоолтой болох байх. Боловсрол давуу эрхтэй хүмүүст биш харин нийтэд эрх тэгш олгогдох байх. Хүний ноёрхол зогсож, зөвхөн Бурханы ноёрхол тогтох байх. Хүний эд эс, эдийн засгийн онол, улс төрийн философи, хүн хоорондын харилцаа, хүч чадал, ажил, тоглоом, энтертайнмент, хөгжим, бодол санаа, спорт болон эрүүл мэнд гээд бидний хүрч болох бүх зүйлд Бурханы хаанчлал уусан нэвчсэн байна байх аа. Бурханы засаглал бүхий л талбарт хүрнэ.

Тэгэхээр Бурханы хаанчлал дэлхийд хэрхэн ирдэг юм бол? Есүсээр дамжуулан Бурханы хаанчлал хүний бие дотор ирсэн. Эхлээд Назарын Есүсийн биеэр тэгээд Христийн үхлээс амилсан биеэр, чуулган буюу Ариун Сүнсээр дүүрсэн Христийн биеэр ирсэн юм. Бид Бурханы хаанчлалыг хүлээн авч, хаанчлалын дагуу амьдрахын тулд бүх хүний нүдний өмнө ил оршдог. Бид Бурханы хүслийг дэлхийд биелүүлэх үед хаанчлал нь бие болон цусаар дамжин бодитоор оршиж эхэлнэ.

Хаанчлалыг бүрэн дүүрэн болгодог зүйл бол Бурханы хаанчлал ирэх үед бидний хаанчлал дуусдагт байгаа юм. Хүний ноёрхлын төгсөх цэг. Бурхан ямар нэг хөтөлбөрт сайн санал дэвшүүлэхээр эсвэл таатай нөхцөл санал болгохоор ирээгүй. Харин Өөрийн ноёрхлоо тогтоох гэж ирсэн. Библид гардаг Херод, Понти Пилат, Цезарь, сатан нар Есүсийг өөрсдөд нь аюултай гэдгийг үнэхээр мэдэж байсан нь миний сонирхлыг татсан. Бурханы хаанчлал өөрсдийнх нь хаанчлалыг төгсгөх гээд байгааг тэд мэдэж байсан. Тэд Есүсийн зааж сургаж буй зүйлтэй санал нийлэхгүй байсан болохоор Түүнийг алах гээд байсан юм биш. Харин өөрсдийнх нь ноёрхлыг дуусгах гэж ирсэн болохоор алах гэсэн юм шүү дээ. Ариусгах нигүүлслийн үр дагавар нь хүний ноёрхлыг төгсгөх гэдгийг та ойлгож чадаж байна уу?

Барбара Браун Тэйлор далайн яст мэлхийний тухай нэг түүх ярьсан байдаг. Яст мэлхий өндгөө элсэнд дарахаар далайн уснаас эрэг рүү гарчээ. Тэйлор хэсэг хугацаанд яст мэлхийг ажиглаж байгаад саад болохгүйн тулд холдон явжээ. Дараагийн өдөр нь яст мэлхийн мөр далай руу биш харин элсэн манхан руу чиглэсэн байхыг харсан байна. Мөрөөр нь дагахад нөгөө яст мэлхий бүр эцэж ядраад наранд бараг л жигнэгдсэн гэлтэй олдсон байна. Тэйлор жийп машинтай далайн эргийн хамгаалагчийг олж уулзаад яст мэлхийг хэрхэн аварч байгааг харснаа ингэж бичжээ.

Би түгшсэн байдалтай харж байх зуур хамгаалагч мэлхийг урвуу нь харуулж нуруугаар нь эргүүлж тавиад, урд хөлийг нь дугуйны гинжээр ороож, гинжээ жийпнийхээ чиргүүлийн бэхэлгээнд тогтоов. Тэгээд урагш хөдөлж мэлхийг чирэхэд мэлхийн ам нь нээлттэй байснаас болоод элсээр дүүрсээр байгаад хүзүү нь хүндэрч доошилсоор доошилсоор алга болсон

тул хүзүү нь хугарчихаагүй байгаа даа гэж би санаа зовов. Хамгаалагч түүнийг элсэн манхнаас эрэг рүү чирэхэд би яст мэлхийн элсэн дээр чирэгдсэн мөрийг дагаад араас нь явсан. Эрэг дээр ирээд хамгаалагч түүнийг буцааж хөл дээр нь босгож тавилаа. Далайн давалгаа ирж яст мэлхийн нүдэнд наалдсан элсийг угааж, түүний арьс хуягийг дахин өнгө оруулж байхад тэрээр хөдөлгөөнгүй байсаар л байв. Тэгээд илүү том давалгаа түүнийг цохиход яст мэлхий толгойгоо өргөж, хойд хөлөө хөдөлгөхтэйгөө болов. Би үргэлжлүүлэн ажигласаар л, шинэ давалгаа мэлхийг ирж цохих болгондоо түүнд амь амьдралыг өгсөөр эцэст нь нэг юм яст мэлхийн хөл тулах цэгтэй болж, давалгаа түүнийг төрсөн гэр болох далайн усанд нь эргүүлэн аваачсан юм. Яст мэлхийг далайн усанд алгуурхнаар алга болохыг харангаа түүнийг элсэн манхнаас хар дарсан зүүд мэт чирэгдсэн мөчийг эргээд бодоход хүний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн гар өөрийг нь амьдруулах гээд байна уу алах гээд байна уу гэдгийг хэлэхэд хэцүү байдаг юм байна даа гэдгийг ойлгож авч билээ.

Бурханы хаанчлал ирэхийн төлөө залбирна гэдэг нь өөрсдийнхөө хувийн сэнтийд ариусгах нигүүлслийг урьж байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл “Эзэн минь, миний амьдралыг урвуугаар нь эргүүлээч. Амьдралын минь хуягийг Өөрийнхөө жийпнээс уяад Өөрийнхөө очих газар уруу намайг чирч, Өөрийнхөө ажилд оролцуулаач, тэгээд надад зориулсан амьдралын төлөө намайг дахин сэргээгээч” гэж хэлж байна гэсэн үг юм. Энэ нь Бурхан уруу очиж, Бурхантай хамт алхаж, бүх хяналтыг Бурханд өгч, Бурханд бууж өгөхийг хэлж байгаа юм. Нэг л өдөр Бурханы хаанчлал бүрэн дүүрнээр ирнэ. Гэхдээ энэ нь хаанчлал одоо энд байхгүй гэсэн үг биш.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их тунгаан бодоосой гэж хүсэж байна вэ? Бурхан танд юу гэж хэлж байна?

ЗАЛБИРЦГААЯ

Их Эзэний заасан залбирлыг өгүүлбэр өгүүлбэрээр нь салгаж залбиръя. Ингэхдээ гуйлт бүрийг өөрийн үгээр илэрхийлээрэй.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Бурханы хаанчлалыг та хэрхэн тодорхойлдог байсан бэ?

2. Ижил утга бүхий гурван өгүүлбэр (Бурханы нэр ариунаар дуурсагдах, Бурханы хаанчлал ирэх, Бурханы хүсэл биелэх)-ээс аль нь танд ариусгах нигүүлслийн үр нөлөөг ойлгоход илүү нээж, тусалж өгсөн бэ?

3. Бурханы хаанчлал бодитоор нэвтрэн орж ирснийг та хаана харсан бэ?

4. Далайн яст мэлхийн түүх таны амьдралтай юугаараа төстэй мэт санагдсан бэ?

5. Ямар үед ариусгах нигүүлсэл “Амьдралыг нь урвуугаар нь эргүүлсэн ч амьдрал уруу хөтөлж байгаа гар” мэт байдаг юм бол?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

3-р долоо хоног

БҮЛГИЙН АРИУСГАЛ

Энэ дэлхийд ямар ч хамаагүй гаднын хүн юм шиг санагдаж байсан үе танд бий юу? Хэрэв бид өөрсдийг маань тодорхойлж байдаг гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй соёлын нөлөөнөөс ангид тусгаар болчихвол өөрсдийнхөө хэн гэдгийг маш амархан мартаж байх. Бид хамааралтай байх, харьяалагдах хэрэгцээнийхээ хүрээнд олонхын дундаас буюу үзэл бодлоор дүүрэн масс дотроос ялгарах тодотголтой байхыг эрмэлзэж болох юм. Байнгын бусдаас ялгарах, өөр байх нь тийм ч таатай, тухтай зүйл биш. Маш цөөхөн нь л гадны хүн байх хүсэлтэй байдаг байх. Бурханд дуулгавартай байх нь биднийг аливаа нэг давамгайлал соёлын хэлхээн дотор бүгдэд харагдахуйцаар ил байрлуулах үед бид хүсээгүй анхаарлаа өөрсөд дээрээ урьсан байдаг юм даа.

Петрийн 1-р захидал яг ингэж мэдэрдэг хүмүүст зориулагджээ. Эхний хэдэн эшлэлд бичээч нь тэдний хэн гэдгийг нь бат итгэлтэйгээр сануулсан байдаг. Тэд бол Бурханы сонгосон гэр, дуулгавартай хүүхдүүд, шинэ Эцэгтэй гэр бүл, үрчлэгдсэн ах дүүс, шинээр төрөгсөд бөгөөд сүнслэг гэрт нэгдсэн амьд чулуу. Эдгээр бүх зүйл ариун зорилгын төлөө байсан. Тэд өмнө нь хүн байгаагүй харин одоо жинхэнэ хүн болсон. Тэд бол сонгогдсон угсаа, хаант тахилч, ариун үндэстэн юм. Тэд бол Бурханы хүмүүс. Петр тэдний хэн гэдгийг нь ойлгуулахдаа хэтрүүлэн сануулсан юм шиг. Хэдийгээр дэлхийд харийн мэт санагдсан ч хэрэв бид өөрсдийгөө хэн гэдгийг мэддэг, өөрсдийгөө хүлээн зөвшөөрсөн бол урваж шарваж буруу талд орохгүй. “Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл. Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун.” (1:14-16). Ариун байдал уруу дуудсан энэ дуудлага Левит 17-26 бүлэгт гардаг

тахилчийн ариун байдлын хэм хэмжээнээс улбаатай. 1 Петр 2:5 болон 2:9 харвал уншигч нь ариун бөгөөд хаант тахилч байхын төлөө босгогдон, байгуулагдаж байгаагаа ойлгоно. Үүнээс харвал гэр бүлд хамаатай бүх зүйл тахилчийн ажил болох нь ойлгомжтой байна. Тэдний дуудлага бол ариун байдал юм. Тахилчийн болон гэр бүлийн дадлын тухай дохио анхааруулга энэ номын турш гарч байгааг харж болно.

=====

**Ариун байдал уруу дуудсан
дуудлага өөрчлөгдөөгүй.**

=====

Ариун байдлын хэм хэмжээ Аарон ба түүний хөвгүүдэд, тэднээр дамжуулан нийт Израйлчуудад бас өгөгдсөн тухай Левит номд гардаг. Бурхан Өөрийнхөө энэрлийг дэлхийн бүх хүмүүст зуучлан, эвлэрүүлэхийн тулд өөрт нь үйлчлэх тахилчийн гэр бүлийг босгон байгуулсан юм. Израйлчууд зорилготойгоор сонгогдсон. Тэнгэрлэг сонголт гэдэг нь танд дуртай учраас сонгож байгаа хэрэг биш харин таныг үйлчлүүлэхийн төлөө сонгож байгаа хэрэг юм. Израйлчууд сонгогдсон нь ямар нэг сайн чанар, давуу талаас нь огт болоогүй. Харин тэд Бурханы ариун сүм байхаар бүтээгдсэн хүмүүс байлаа.

1 Петр номын зохиолч цөллөгт байгсдын тухай дурдахдаа уншигчийг Израйлчуудын дуудлага болон Есүс рүү чиглүүлсэн. Энэ нь зөвхөн Иудейн сүм болон тахилын системийг дахин сэргээх тухай биш харин сүм болох Есүсийн биеэр дамжуулан Бурханы чөлөөлөлтийг үргэлжлүүлэх тухай байсан юм. Тэд яг л Бурханы тахилчаар дуудсан Израйлчууд шиг Бурханы шаарддаг ёс суртахууны дагуу амьдардаг байсан. Ариун байдал уруу дуудсан дуудлага өөрчлөгдөөгүй. Өнөөдөр ч гэр бүлүүдэд энэ нь хамаатай байсаар байгаа.

Ариун байдлын тухай ярих үед зарим хүн хатуу тогтсон хуулийн систем, цэвэр болон цэвэр бусын хоёр туйлт хязгаар, халдашгүй ариун болон бузар зүйлийн тухай маш хурдан төсөөлж эхэлдэг. Энэ мэт систем нь эрс өөрчлөлт хийхээсээ илүү хориглосон нөхцөлүүдээрээ илүү танигддаг. Бодит байдал дээр Есүс яг ийм л тогтолцоог сорьсон юм. Марк 1-3 бүлгийг харвал, Есүс хуульд ариун гэж заасан бүх зүйлийг яг эсрэгээр нь үйлдэж байгааг харж болно. Амралтын өдөр хүн эдгээх, уяман өвчтэй хүнд хүрэх, харь хүмүүстэй хооллох зэрэг нь Бурханы Хүүгийн хийсэн

өөрчлөлтүүдийн зөвхөн өчүүхэн хэсэг нь. Петрийн уриалсан ариун байдал нь хориглосон заалт бүхий тогтолцоог бий болгож, тэдгээрийг биелүүлснээрээ Бурхантай холбогдох тухай огт биш. Харин Бурханы жинхэнэ чанар болох хайр болон нигүүлслийн тусгал болох тухай юм. “Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртсэн байна” (2:10). Бурханых гэдэг айлд багтах нь нэр хүнд олж авах, онцгой тактик, эсвэл зүгээр ариун дүр эсгэн тоглож байгаа хэрэг огт бишээ. Харин Бурхан ямар ариун байдаг шиг тийм ариун байна гэсэн үг юмаа.

Цэвэр байдлын тогтолцооны анхдагч алдаануудын нэг нь тусгаар байдал байсан. Цэвэр байдал нь ганц хүний гүйцэтгэл дээр суурилж эхэлбэл бусдаас хамааралтай байдал нь ганцаарчилсан спорт шиг болж хувирдаг. Гэвч хүмүүсийн хамтдаа гаргаж буй үр дагавар дээр Бурханы хүсэл байдаг. Энэхүү номонд гарч буй нэг ч үг бие даасан, тусгаар гэх утга илэрхийлээгүй. “Хүүхдүүд” гэдэг үгний цаана гэр бүл гэсэн утгыг, “Эцэг” гэх үгний цаана хүүхдүүд гэсэн утгыг илэрхийлж байна. Сүнслэг гэрүүдэд маш олон амьд чулуу байх ёстой. Эс бөгөөс бид зүгээр л чулуун овоотой адил болох болно. Ариун тахилч гэж зориулалт бүхий гэр бүл эсвэл ариусгагдсан үйлчлэгч нарыг хэлж байна. Харин сонгогдсон ард түмэн гэж маш олон хүнийг хэлж байгаа юм. Бурханых гэгддэг гэр бүлтэй холбоотой эдгээр үг бүгд олон тоон дээр яригддаг. Цэвэр амьдарч, ариун байдал уруу дуудагдана гэдэг нь бусадтай хамтарна гэсэн үг. Петр энд ариун гэр бүл бий болгох тухай бичсэн. Бие биеэ хайрлаж байгааг маань харснаараа тэд биднийг Христэд итгэдгийг мэдэх болно.

=====
**Сүнслэг гэрүүдэд маш олон
амьд чулуу байх ёстой. Эс бөгөөс
бид зүгээр л чулуун овоотой
адил болно.**
=====

Зарим тайлбарлагч 1 Петр номыг баптисмын тайлбар ном, усан баталгаа хүртсэн хүмүүст Бурханы гэр бүлд шинээр төрж байгааг нь тайлбарлан, зааварчилгаа өгч буй захидал гэж үздэг. Тэд бол Бурханыг төлөөлөн харуулахын тулд Бурханаар сонгогдсон, Бурханы ариун байдлыг хуваалцахаар дуудагдсан, Христийн үнэт цусаар боолчлолоос аврал уруу аваачигдсан, шинэ Эцэгтэй болсон, ах дүү нараа хайрлахын тулд цэвэршүүлэгдсэн, төлөвшихийн тулд сүнслэг сүүгээр тэжээгдсэн, Бурханы гэрт шилдэг Өрлөгчнөөр амьд чулуу болгон босгогдсон, ариун тахилч байхаар тослогдсон хүмүүс юм. Энэхүү авралын цогц мөн чанарт ямар ч алдаа байхгүй. Энэ нь хувь хүнийг төлөвшүүлэхээс илүү чуулганыг төлөвшүүлэх тухай юм. Бурхан өөрийн ард түмнийг бий болгож байна.

ЗАЛБИРЦГААЯ

1 Петр номд Бурханы хүмүүсийг хэн гэж тодорхойлсныг дахин нэг хараарай. Тодорхойлолт бүрт хэсэг хугацаа зарцуулж, эдгээр тодорхойлолтыг биелүүлж амьдрах чин зориулалт байгаагаа Бурханд илэрхийлээрэй. Жишээлбэл, таны хувьд Бурханы сүмд бусад итгэгчидтэй хамт урлагдсан амьд чулуу байна гэдэг нь юу гэсэн үг вэ?

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. “Ариун байдал” гэдэг үгийг сонсохоор танд юу төсөөлөгддөг вэ?

2. Петр тухайн хүний тодорхойлох үзүүлэлтийг зан чанартай нь холбосон. Бид өөрийгөө хэн гэж боддог ойлголт дээрээ тулгуурлан өөрсдийгөө илэрхийлдэг. Биднийг илэрхийлдэг тодорхойлолт үзүүлэлтийн хэдэн хувь нь бидний төрөлх зан чанар байдаг бол?

3. Энэ хэсэгт ашигласан биднийг тодорхойлдог гэр бүлийн хүчин зүйлээс аль нь танд хамгийн их тохирч байна вэ?

4. Ариусгал нь яагаад бүлгийн үйл ажиллагаа вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

4-р долоо хоног

АРИУСГАГЧ СҮНС

Эхлэл 2:7-оос харахад, Бурхан бидний шороон бие дээгүүр сунаж, амьсгал өгснөөр биднийг амьд оршигч болсон тухай гардаг. Энэ ариун амьсгалыг Еврейгээр руах гэдэг ба “салхи”, “сүнс” гэсэн утгаар илэрхийлдэг. Энэ л зүйлээс болж бид амьд оршигч буюу Еврей хэлээр нефеш болсон юм. Энэхүү сонирхолтой үгийн язгуур утга нь бидний доторхыг гадагшаа илэрхийлдэг гарц гэсэн утгатай “хоолой” гэдэг үг байдаг. Бид бол ус, хоол хүнс, амьсгал гэх мэт амьдрал тэтгэхэд шаардлагатай гадаад бүх зүйлд нээлттэй байдаг бүтээл билээ. Бид тусгаар, бие даасан амьтад биш. Бидний дотор дүүргэх шаардлагатай нүхнүүд байдаг. Бид бол Бурханаар дүүргэгдэх чадвартай хоосон орон зай юм.

Гурвалын нэг нь Ариун Сүнс, тэнгэрлэг руах, Бурханы амьсгал гэдэгт гайхах зүйл алга. Эхлэл номон дахь бидний бүтээгдсэн үеэс, Езекиел номын хувхай ясаар дүүрэн хөндий, цаашлаад Үйлс номын Пентекостын хүчит хуй салхины үеүдэд Бурханы хөдөлгөөнийг тэнгэрлэг салхи, амьсгал, нэвтрэн орж буй Сүнс, сэргээгдсэн хүмүүс гэж тодорхойлсон. Сүнсээр дүүргэгдсэн үед юу ч тохиолдож болно. Хуучин Гэрээнд Сүнс эш үзүүлэгчид дээр ирэхэд тэд үсээ хусах, нүцгэн номлох, өтөг бууц дээр хоол хийх, биеэ үнэлэгчтэй гэрлэх, хуйлмал бичээс идэх, голын дэргэдэх чулуун доор дотуур хувцсаа нуух зэрэг хачин үйлдлүүдийг хийсэн байдаг. Өнөөдөр бидний хувьд Сүнсээр дүүрэн байгаагийн нотолгоо нь Христтэй хэр адилхан байгаагаар илэрхийлэгдэнэ. Бурхан биднийг тэнгэрлэг нигүүлслээр дүүргэх үед бид Есүсийн дүр төрхийн дагуу шинэчлэгддэг. Үхлээс амилж бидний дотор амьдардаг Эзэний Сүнсийг Ариун Сүнс гэдэг. Дэлхийд дагалдагч нар биш Есүс таалагдаж байгаа бол бид энэ тасалдалд гүнзгий анхаарах ёстой. Хэдийгээр бид Есүстэй илүү адилхан баймаар байна гэж хэлдэг ч энэ нь бидний үнэхээр хүсэж байгаа зүйл мөн үү гэдэгт эргэлзэж байна. Лукийн бичсэн Сайнмэдээний Лук ном болон Үйлс номыг хамтдаа харъя.

=====

Хэрэв Есүсийн тухай уншвал Түүнийг аливаа ангиллын хайрцгийг хоосолж, сэтэр шошгыг хийсгэн үлээдэг салхи гэдгийг төвөггүй ойлгоно.

=====

Лукийн Сайнмэдээний номоос харвал Сүнс түүний дотор байдаг учраас Есүс Мариас төрсөн Нэгэн гэжээ. Тэрээр Сүнс дээр нь буун ирж, Иоханаар баптисм хүртсэн Нэгэн юм. Тэрээр цөлд Сатанаар соригдон, Сүнсээр хүчирхэгжсэн Нэгэн юм. Есүс бол Бурханы амьсгал, бидний дунд хөдөлж буй тааламжит хүчит салхи билээ. Түүний ажил нь сайнмэдээ. Гэвч хүч чадал болон эрх мэдэлтэй хүмүүсийг Есүс сүйрүүлдэг гэдгийг бид маш амархан харж болно. Лукийн өдрүүдэд Есүсийг өөр өөр байдлаар таньж мэдсэн хүмүүсийг хэд хэдэн бүлэгт тодорхойлж болох ангилал байв. Биеэ үнэлэгч, фарисай, саа өвчтэй, гахай маллагч, садукай, гэмтэн, цэрэг, зөвлөлийн гишүүн, амралтын өдрийг үл сахигч, татвар хураагч, уяман өвчтөн, гэмтний нөхөр гэх мэт тодорхойллын ангиллууд сайнмэдээний бүх номд гардаг. Бид ч өнөөдөр бас л адилхан. Ангилал гэдэг дээр нэмээд хэлэхэд бид эдгээр ангилагдсан хүмүүсээ хийх хайрцгийг нь ч бас хийчихсэн байдаг шүү. Бид хүмүүсийг сайн/муу, цэвэрхэн/халтар, нэг тал/эсрэг тал гэж ангилдаг. Хэрэв Есүсийн тухай уншвал Түүнийг аливаа ангиллын хайрцгийг хоосолж, сэтэр шошгыг хийсгэн үлээдэг салхи гэдгийг төвөггүй ойлгоно. Бид үнэхээр Есүс шиг байхыг хүсэж байгаа гэж үү?

Товчхон судалгаа хийе. Лук номын 4-р бүлэгт, Есүс төрсөн нутагтаа очоод Исаиагийн хуйлмал номоос Сүнс Түүний дээр буусан тухай уншдаг. Хүмүүс Түүнээс гайхамшиг үзүүлж нотлохыг шаардахад Есүс шүтлэггүй бэлэвсэн эмэгтэй болон дайсны цэргийн дээр Бурханы таалал буун ирсэн тухай өөрсдийнх нь Бичээс дэх Хаадын Дээд болон Хаадын Дэд номоос уншиж өгөн сануулдаг. Есүсийн Сүнсээр дүүрэн байдал нь буруу ангилагдсан, муу хайрцаг дахь хүмүүст үйлчилж байсан учраас хүмүүс Түүнийг хавцлын ирмэгт алахаар авчирдаг боловч (одоо ч гэсэн) амжилт

олдоггүй. Харин Есүс “буруу” гэж хаяглагдсан хүмүүст үйлчилсээр л байна.

Лук 4:35-д Тэр сүнсэнд эзэмдүүлсэн хүнийг эдгээдэг бол 5:13-д уяман өвчтэй хүнд хүрдэг. Харин 7:10-д Ромын цэргийн зарцыг эдгээдэг. 7:14-15-аас харвал үхсэн хүнийг амилуулсан. 7:38-д нүгэлтэй эмэгтэйд хөлийг нь тослохыг зөвшөөрдөг. 8:2-т Есүсийг дагаж явдаг байсан хүмүүсийн нэг нь урьд нь долоон муу сүнсэнд эзэмдүүлсэн эмэгтэй байсан тухай гардаг. 8:26-д Герас хотод хамгийн муу бүхнийг хийсэн гэж тооцогддог муу сүнсэнд эзэмдүүлсэн хүний тухай байдаг. 8:43-т цус алдах өвчтэй эмэгтэй Есүст хүрснээрээ буруутгал биш эдгэрлийг авсан тухай уншина. 9:42-т Тэр чөтгөрийн сүнсэнд эзэмдүүлсэн хүүг чөлөөлсөн бол 13:12-т амралтын өдөр бөгтөр эмэгтэйг эдгээсэн тухай гардаг. 17:14-д уяман өвчтэй арван хүнийг эдгээдэг. 18:42-т сохор гуйлгачныг хараатай болгодог. 19:2-т Есүс татвар хураагч Закхайтай оройн зоог барьдаг. Лукийн сайнмэдээний номоос харвал буруу, муу гэж хаяглагдсан хүн бүр рүү Есүс тасралтгүйгээр, мөн санаатайгаар ойртсоор байсан. Энд л бид Сүнсний салхи Есүсийг хөдөлгөж байгааг харж болно. Би дахин асууя. Есүстэй адилхан баймаар байгаадаа та итгэлтэй байна уу?

Сайнмэдээний энэ номын төгсгөлд үхлээс амилсан Есүс дагалдагч нарынхаа өмнө үзэгдэж “Судрыг ухааруулахын тулд тэдний оюун ухааныг нээж” (24:45) “дээрээс ирэх хүчийг өмстлөө” (эшлэл 49) байгаа газраа үлдэх тухай зааварладаг. Хүмүүсийг Бурханы хаанчлалын гэрч болгохоор Ариун Сүнсний амьсгал хүмүүсийг хүчирхэгжүүлэхээр ирж байгаа тухай Есүс хэлдэг. Лук ном дуусдаг ч Үйлс ном Бурханы амьсгал тааламжит хүчит салхи-руах лугаа адил ирж байгаагаар үргэлжилнэ. Тэрээр өрөөг дүүргэж, хүмүүсийн тархинд

хамгийн ойрхноор буюу толгой дээр нь ариусгах гал асааснаар тэдний Бурханы тухай бодох бодол болон бусад хүмүүсийн тухай бодох бодлыг цэвэршүүлдэг. Тэд Ариун Сүнсээр дүүрч, өмнө нь хэзээ ч сурч байгаагүй хэлээрээ ярьж эхэлдэг. Есүсийн гэрч болон хүрч очно хэмээн хэзээ ч төсөөлж байгаагүй газарт Бурханы салхи хүмүүсийн хэл болон чихийг аваачдаг. Соёлын хувьд эсрэг тэсрэг Есүсийн дагалдагч нарыг Ариун Сүнс нэгтгэдэг. Тэднийг нэгтгэж байгаа зүйл нь нийтлэг ангилал, хайрцаг биш харин өөрсдөөс нь өөр хүмүүс рүү дуудаж буй нэг ижил дуудлага юм. Сүмийн гол холбоо нь бидний хоолойгоор урсаж, толгой дээр ассан ариусгах гал байхаас гадна бидний ялгаж, шүүж, буруутгаж, үл ойшоож болох тэдгээр хүмүүсийн төлөөх дуудлага билээ.

Ариусгах Сүнс нь зөвхөн биднийг эелдэг, илүү өгөөмөр болгож, муухай аашийг маань багасгадаг зүйл бишээ. Харин бусдын тухай бодох бодлыг маань өөрчилдөг Бурханы хөдөлгөөн ба өөрсдийгөө хүмүүсийг хайрладаг Есүсийн элчин сайдын хувьд хүмүүсийн дунд тавих тухай юм. Ариусгах Сүнс нь Есүсийн явсан газарт явж, хийдэг зүйлийг нь дуурайн хийдэг хүмүүсийг бий болгодог. Бид ангилал ялгаагаар биш харин алдагдсан хүмүүсийн төлөөх дуудлагаар нэгддэг.

Ертөнцийн харанхуй хүч биднийг өөрсдийнхөө ашиг сонирхлын араас явахыг л заадаг. Мөн биднийг хүмүүсийг ялгаж, шүүж, ангилан хайрцаглаасай гэж хүсдэг. Харин ингэх нь үхэл ба хуваагдлын зам юм шүү. Гэвч энэ ертөнцөд биднийг бие биеэ хайрлахад, бие биедээ үйлчлэхэд, Есүсийг гэрчлэхэд урамшуулдаг өөр нэг хүч болох салхи байдаг. Тэр хүч бол Бурханы ариусгагч Сүнс юм.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их тунгаан бодоосой гэж хүсэж байна вэ? Бурхан танд юу гэж хэлж байна?

ЗАЛБИРЦГААЯ

Та Пентекостийн үед амьдарч байна гэж төсөөлөөрэй. Өнөөгийн байдлын тухай Бурхантай ярилцаарай. Сүнсээр дүүргэгдсэн хүмүүсийн дунд амьдарч байгаагийнхаа хувьд та өөртөө ямар найдлага тээж байгаагаа илэрхийлээрэй.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Сүнсээр дүүрэх гэсэн ойлголтыг Чуулган Есүсийн дүр төрхөөр шинэчлэгдэх гэснээс өөрөөр хэрхэн тайлбарладаг бэ? Христийг гэрчлэгч байхтай холбоотой гардаг ямар асуудлыг энэ ойлголт бидэнд харуулдаг вэ?

2. Ариусгах нигүүлсэл таны хувийн болон нийгмийн амьдралд хэрхэн тунхаглагдсан бэ?

3. Ариусгах Сүнс таныг өөрөөсөө өөр хүмүүсийг хайрлахад, тэдэнд гэрчлэхэд яаж урамшуулдаг вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

АРИУСГАХ НИГҮҮЛСЭЛ

Бид Бурханы угтал нигүүлсэлд хариу үзүүлж, Бурханы авралыг хүлээн авсны дараа бэлэг болох ариусгах нигүүлсэл болох Бурханыг үргэлжлүүлэн илүү сайн мэдэх, ариун байдалд хүргэх зам бүхий Христийг дагах аялалд уригддаг. Бурханы ариусгах нигүүлсэл нь биднийг бүрэн цэвэршүүлж, Түүний дүр төрхийг итгэмжтэйгээр тээхийг эрэлхийлдэг болгохын зэрэгцээ сүнс дотор төлөвших боломжийг бидэнд олгодог. Бүлэг бүр ариусгах нигүүлслийн мөн чанарын тухай тунгаан бодох хэсэг, тэмдэглэл хөтлөх хэсэг, залбирлын сэдэв, жижиг бүлгүүдэд зориулсан хэлэлцүүлгийн асуултаар өндөрлөнө.

НИГҮҮЛСЛИЙН АЯНЫ ЦУВРАЛУУД

Ахин дахин үнэгүй өгөгдсөн Бурханы нигүүлсэл нь бүхий л хэлбэрээр бидэнд хэрэгтэй тэрхүү нигүүлсэл мөн. Бидний хэлдгээр, Христэч амьдрал бол нигүүлслээс нигүүлслийн хооронд өрнөдөг. Бурхан бидний замыг бэлтгэхийн тулд бидний урд алхдаг. Бурхан биднийг аварч, гэмээс чөлөөлсөн. Тэрээр биднийг ариун байдлын замаар удирдан дагуулдаг. Дөрвөн долоо хоногийн хугацаанд үзэх хичээл тус бүрээр бид Өөрийн хүмүүстэй өгсөн Бурханы олон төрлийн өгөөмөр хайрынх нь талаар илүү гүнзгий судлах бөгөөд ийнхүү бидний итгэлийн амьдрал жинхэнэ Нигүүлслийн Аялал болох болно.

ДЭН БҮҮН нь Трэвэка Назарын Их Сургуулийн (АНУ-ын Нэшвилл дэх) ерөнхийлөгчөөр ажилладаг. Тэрээр Назарын Теологийн Сургууль болон МоКормик Теологийн Сургуульд тус тус суралцан, Дивинити Магистр, Министри Магистрийн зэрэг хамгаалжээ.Тэрээр шилдэг борлуулалт бүхий Маш ихээр гажуудсан дэлхийн Маш Сайн Бурхан, Лук, Үйлс, 1 ба 2-р Петр, Илчлэлт зэрэг номуудад тулгуурлан бичсэн Бичээсээр Хэлбэржсэн зэрэг номуудын зохиолч бөгөөд эдгээр номыг Фаундри хэвлэлийн газраас шууд авах боломжтой.